



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!


№33 /477/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.02.15

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛ ЦЭРГИЙН ЭМЧ НАР ОДООГИЙН БАЙДЛААР 467 ХҮНД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭЭД БАЙНА



БНТУ-ын Хатай муж Антакья хотод дэлгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний Цэргийн эмнэлэг өчигдөр буюу 2 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар гэмтлийн болон бусад шалтгаант нийт 66 иргэнд /8 хүүхэд/ тусламж үйлчилгээг үзүүлээ.

Мөн Турк Улсын Эрүүл мэндийн яамны гадаад харилцааны орлогч дарга Монгол Цэргийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар ярилцаж, эмнэлгийн үйл ажиллагаанд амжилт хүссэн байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Цэргийн хээрийн эмнэлгийн бие бүрэлдэхүүн БНТУ-д үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш нийт 467 хүнд /56 хүүхэд/ эмнэлгийн анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,517	3,522
EUR	3,790	3,805
CNY	515	517
RUB	46	46.70
JPY	26.60	26.80
KRW	2.75	2.78

ЗУРХАЙ



2023.02.15 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 25

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал: Нүд бүрэлзэн улцайна НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.59-18.13 БАРИЛДЛАГА: Идэр Шүтэн БАРИЛДЛАГА: Нэр өнгө

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалын хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олодох, баруун чих хангинавал ундаа олодох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олодох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Өнөөдөр буюу 2 дугаар сарын 15-ны өдөр ҮБХИС-ийн харьяа БХЭШХ-ээс "Төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын эмэгтэйчүүд энхийн үйлсэд" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг ҮБХИС-ийг түшиглэн зохион байгууллаа.

Хуралд Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй энхийг сахиулагчдын төлөөлөл оролцож эмэгтэй цэргийн алба хаагчдын энхийн үйлс, аюулгүй байдлын салбар дахь өнөөгийн үүрэг, оролцоонд дүн шинжилгээ хийж, тэдний гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх, энхийг дэмжих ажиллагаан дахь оролцоог нэмэгдүүлэх арга замын талаар хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын индрээс "Монгол Улс 2027 он гэхэд энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн оролцоог 15



хувь хүртэл нэмэгдүүлэх" тухайгаа онцлон тэмдэглэсэн. Мөн Монгол Улсад зохион байгуулагдсан "Эмэгтэйчүүд энх тайван ба аюулгүй байдал" сэдэвт олон улсын хурлын үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Энхийн ажиллагааны газрын дарга Жан Пьер

Лакура "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх" өргөн хүрээний чиг үүргийг гүйцэтгэх зорилтын хүрээнд тодорхой бодлого боловсруулан, хэрэгжилтийг хангах"-

ыг гишүүн орнууддаа уриалсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын төр засаг, БХЯ, Зэвсэгт хүчний удирдлага эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог шат дараатайгаар нэмэгдүүлж байна.

Тухайлбал, Монгол Улсын Зэвсэгт хүчин 2006 онд анхны эмэгтэй цэргийн алба хаагчаа Баруун Сахар дахь энхийг сахиулах ажиллагаанд илгээснээс хойш энэ тоо 1000-д хүрээд байна. Энэ нь Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний багагүй хувь, мотобуудлагын батальоны 7 хувийг тус тус эзэлж байгаа төдийгүй уг үзүүлэлтээрээ энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээдэг НҮБ-ын гишүүн 112 улсаас 17 дугаарт, Зүүн хойд Азийн орнуудын дунд 1 дүгээрт тус тус эрэмбэлэгдэж байна.

Ө.НАСАНТОГТОХ

## САРА ГҮҮДРОУ: ХАМТРАН АЖИЛЛАХДАА ТААТАЙ БАЙХ БОЛНО

Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцох эмэгтэй цэргийн алба хаагчдынхаа тоог нэмэгдүүлж, нийт бие бүрэлдэхүүний 15 хувьд хүргэх зорилт дэвшүүлснийг бид бүрэн дэмжиж байгаа. АНУ-ын хувьд ч ялгаагүй энхийг сахиулах үйлсэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна. Ер нь энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй эмэгтэйчүүдэд тулгардаг олон саад бэрхшээл

бий шүү дээ. Тухайлбал, соёлын ялгаатай байдал, гэрээсээ алслагдмал газар оронд үүрэг гүйцэтгэх үед ар гэрийн асуудал орхигдох, жендерийн хувьд ялгамжтай хандах зэргийг дурдаж болно. Тус эрдэм шинжилгээний хурлаар дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар туршлага солилцож, гарц шийдлийг хамтран хэлэлцлээ. Бид энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр

хамтран ажиллахдаа тун таатай байх болно. Монгол Улсын хувьд энхийг сахиулах ажиллагаанд оролцох зорьж буй түвшин нь өндрөөр үнэлэгдэхүйц үзүүлэлт бөгөөд өөрийн бус нутаг болон дэлхий дахинд үлгэр дуурайлал болж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин нь зорилгоо биелүүлэх нөөц бололцоо, ажил хэрэг болгох бүрэн чадамжтай.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 677,940,157

Эдгэрсэн

Нийт: 650,524,905

Нас барсан

Нийт: 6,784,511

Цахим шууданд

## АХМАД ДАЙЧИНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар нар Булган аймагт ажиллалаа. Энэ үеэр Булган аймгийн Дашинчилэн сумын харьяат өндөр настан, ахмад дайчин Д.Доржид БХЯ болон Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олноос хүндэтгэл үзүүлжээ. Ахмад дайчин Д.Дорж нь 1945 оны Чөлөөлөх дайнд оролцон эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө тэмцэж явсан гавьяат үйлстнүүдийн нэг юм.

## АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Хуваалцах Жиргэх Билгийн тооллын XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх Усан туулай жилийн сар шинийн баярыг угтаж энэ сарын 10-ны өдөр ЗХЖШ-аас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадууддаа хүндэтгэл үзүүлжээ. Энэхүү арга хэмжээгээр Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал ахмадуудаа хамтатган хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн юм. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал Хуурай замын цэргийнхний 2022 оны ололт амжилтыг тодотгож, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх болон алба хаагчдын ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлуудаа онцолж, ахмад буурлуудын санал сэтгэгдлийг нь сонсож, хүндэтгэлийн зоог хамтдаа барьсан юм.

## СПОРТ БОЛОН ОЮУНЫ ОЛОН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНЭЭР ӨРСӨЛДӨЖ БАЙНА



Ирэх сарын 2-ний өдөр тохиох Монгол хурандаа нарын өдрийг угтан Монгол Хурандаа нийгэмлэг нийт гишүүдийнхээ дунд спорт болон оюуны олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж байна.

Тухайлбал, энэ цаг мөчид ҮБХИС, ШШГЕГ, Хил хамгаалах байгууллагуудыг түшиглэн Монгол хурандаа нийгэмлэгийн гишүүд теннис, шатар, биллиард зэрэг тэмцээнээр өрсөлдөж аваргаа тодруулж байна.

Ташрамд дуулгахад Монгол Улс 1936 оны 3 дугаар сарын 6-ны өдөр анх удаа хурандаа цолыг олгосон бөгөөд үүнээс хойш Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний түүхэнд 3000 гаруй хурандаа цолтон төрөн гарч эх орон, ард түмнээ сахин хамгаалах үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсаар иржээ.

Гэрэл зураг-нэг агшин



## Амжилтын үндэс нь бэлтгэл

## АЗИ ТИВ ДЭХ ХҮЧ ЧАДАЛ, НӨЛӨӨНИЙ ХҮРЭЭГЭЭР 26 ОРНЫГ ЖАГСААХАД:

### LOWY INSTITUTE

Австралийн "Lowy" институтээс 2018 оноос хойш жил тутам Ази тивийн хэмжээнд улс орнуудын хүч чадал, нөлөөний хүрээний үнэлгээг индексээр гарган үзүүлж буй. Одоо байгаа хүчнүүдийн нөлөөллийн зураглалыг гаргахаас гадна улс орнуудын хүч нөлөөний тэнцвэрт байдлын өөрчлөлтийг цаг тухайд нь гаргагдаараа онцлогтой. Дээрх байгууллагаас 2023 оны шинэ тайлан гарсан байх тул сонирхуулах үүднээс нийтэлж байна.

2023 оны тайлангийн тухайд 2022 он хүртэлх Ази тив дэх хүчний хуваарилалт, нөлөөний хүрээний өнөөдрийг хүртэлх өөрчлөлт бүхий 5 жилийн цогц үнэлгээг хийснээрээ онцлог болжээ.

Австралийн "Lowy" институтээс Азийн орнуудын хүч чадал, нөлөөний хүрээний индексийг гаргахдаа соёлын нөлөөлөл, дипломат нөлөөлөл, батлан хамгаалахын хамтын ажиллагаа, эдийн засгийн нөөц, эдийн засгийн чадавх, цэргийн чадавх, сөрөн тэсвэрлэх чадавх, ирээдүйн нөөц бололцоо гэсэн үндсэн 8 шалгуур үзүүлэлтийг харгалздаг. Эхний 4 үзүүлэлтийн тухайд тухайн орны бүс нутаг дахь нөлөөллийн түвшнийг үнэлж, газарзүйн байршилд нь гол анхаарлаа хандуулсан байна.

### Австралийн "Lowy" институтийн 2023 оны индексээр Ази тив дэх хүч чадал, нөлөөний хүрээгээр 26 орныг жагсаахад:

- Нэг. АНУ
- Хоёр. БНХАУ
- Гурав. Япон
- Дөрөв. Энэтхэг
- Тав. ОХУ
- Зургаа. Австрали
- Долоо. БНСУ
- Найм. Сингапур
- Ес. Индонези
- Арав. Тайланд
- Арван нэг. Малайз
- Арван хоёр. Вьетнам
- Арван гурав. Шинэ Зеланд
- Арван дөрөв. Тайвань
- Арван тав. Пакистан
- Арван зургаа. Филиппин
- Арван долоо. БНАСАУ
- Арван найм. Бруней
- Арван ес. Бангладеш
- Хорь. Камбож
- Хорин нэг. Шри Ланка
- Хорин хоёр. Мьянмар
- Хорин гурав. Лаос
- Хорин дөрөв. Монгол
- Хорин тав. Балба
- Хорин зургаа. Папуа Шинэ Гвиней

Дээрх 26 орноос ерөнхий жагсаалтад энэ жил Бруней, Камбож, Лаос гэсэн 3 орон өмнөх жилийнхтэй харьцуулбал оноо ахиулсан байна. Цэргийн чадавх гэсэн тусдаа шалгуур үзүүлэлттэй ангилалд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон гэсэн 4 орон энэ жил оноо ахиулжээ. Дипломат нөлөөлөл гэсэн шалгуур үзүүлэлтээр БНХАУ, Энэтхэг, Австрали, БНСУ, Индонези, Вьетнам орон энэ жил оноо ахиулсан байна.

### Ази тивд дипломат нөлөөллөөр тэргүүлж буй орнууд:

- Нэг. БНХАУ
- Хоёр. АНУ
- Гурав. Япон
- Дөрөв. Энэтхэг
- Тав. Австрали
- Зургаа. БНСУ
- Долоо. Индонези
- Найм. ОХУ

Ес. Вьетнам  
Арав. Сингапур  
**Ази тивд цэргийн чадавхаар тэргүүлж буй орнууд:**

- Нэг. БНХАУ
- Хоёр. АНУ
- Гурав. Япон
- Дөрөв. Энэтхэг
- Тав. Австрали
- Зургаа. БНСУ
- Долоо. Индонези
- Найм. ОХУ
- Ес. Вьетнам
- Арав. Сингапур

Монгол Улс 2023 онд Ази тивдээ хүч чадлын индексээр 100 онооноос 5 оноо авч 26 орноос 24 дүгээр байранд эрэмбэлэгджээ.

Өмнөх жилийн тайлантай харьцуулбал 0.7 оноо алдаж 12 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тодруулбал тус тайланд дурдсанаар Монгол Улс нь Азийн жижиг орон бөгөөд сүүлийн 1 жилийн хугацаанд хүч чадал, нөлөөний хүрээний индекс гаргахад 0.7 оноогоор буурсан үзүүлэлттэй байна гэжээ. Монгол Улсын тухайд 8 шалгуур үзүүлэлтээр авсан оноо харьцангуй жигд бөгөөд сөрөн тэсвэрлэх чадавх болон батлан хамгаалахын хамтын ажиллагаагаар аль алинд нь 22-р байранд жагссан. Харин соёлын нөлөөний шалгуур үзүүлэлтээр 24-р байранд жагсжээ. 2022 оны индексээс оноо буурсан үзүүлэлтийг харахад Монгол Улс нь бүс нутагтаа өөрийн боломжит нөөц бололцооноосоо бага нөлөөлөл үзүүлж байгаад оршиж байна.

Ази дахь Монгол Улсын хүч чадал, нөлөөний хүрээний 2023 оны тайланг өмнөх жилийн тайлантай харьцуулан үзэхэд батлан хамгаалахын хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээ 0.9 оноогоор, соёлын нөлөөлөл 0.7 оноогоор тус тус ахисан бол эдийн засгийн чадавх 0.7 оноогоор, цэргийн чадавх 1.2 оноогоор, дипломат нөлөөлөл 4.5 оноогоор тус тус буурсан байна.

### Оноог задлан үзвэл:

2023 онд Монгол Улс батлан хамгаалахын хамтын ажиллагаанд хамгийн өндөр оноо буюу 0.9 оноо ахиулж чаджээ. Харин дипломат нөлөөлөл гэсэн шалгуур үзүүлэлтэд хамгийн их буюу 4.5 оноо алдсан байна. Соёлын нөлөөлөл гэсэн шалгуур үзүүлэлтээр 0.7 оноо ахиулав. Харин цэргийн чадавх гэсэн шалгуур үзүүлэлтэд 1.2 оноо, эдийн засгийн чадавх гэсэн шалгуур үзүүлэлтэд 0.7 оноо алдсан байна. Эдийн засгийн харилцаа, ирээдүйн нөөц, сөрөн тэсвэрлэх чадавхын оноо энэ жил өөрчлөгдөөгүй буюу өмнөх жилийнхтэй ижил түвшинд байна.

### Монгол Улсад нөлөөлөл үзүүлж буй улс орнуудад:

БНХАУ 57.3 хувь, Швейцар 13.3 хувь, ОХУ 11.3 хувь, Европын Холбоо 4.5 хувь, Япон 3.2 хувь тус тус орж байна.

Харин Монгол Улсаас нөлөөлөл үзүүлдэг улс орнууд гэсэн ангилалд: ОХУ 0.2 хувь (1.39 тэрбум ам.долларын худалдаа), БНХАУ 0.1 хувь (6.65 тэрбум ам.долларын худалдаа) тус тус орж байна.

**Эх сурвалж: Австралийн "Lowy" институт**